



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 06 өдөр

Дугаар 4/50

Улаанбаатар хот

Албан тушаалтны тодорхойлолтын
загвар батлах тухай

Монгол Улсын Эрүүл Мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолыг ханган ТУШААХ нь:

1. Ажлын хэсгийн боловсруулсан чанарын менежерийн албан тушаалтны тодорхойлолтыг нэгдүгээр, архив, бичиг хэргийн ажилтны албан тушаалтны тодорхойлолтыг хоёрдугаар, их эмчийн албан тушаалтны тодорхойлолтыг гуравдугаар, тасаг хариуцсан эмчийн албан тушаалтны тодорхойлолтыг дөрөвдүгээр, жолоочийн албан тушаалтны тодорхойлолтыг тавдугаар, дотоодын хяналтын ажилтны албан тушаалтны тодорхойлолтыг тавдугаар, хүний нөөцийн мэргэжилтэнгийн албан тушаалтны тодорхойлолтыг зургаадугаар, дотоод хяналтын ажилтны албан тушаалтны тодорхойлолтыг долоодугаар, нягтлан бодогчийн албан тушаалтны тодорхойлолтыг наймдугаар, няравын албан тушаалтны тодорхойлолтыг есдүгээр, статистикчийн албан тушаалтны тодорхойлолтыг аравдугаар, дархлаажуулалтын сувилагчийн албан тушаалтны тодорхойлолтыг арван нэгдүгээр, лаборантын албан тушаалтны тодорхойлолтыг арван хоёрдугаар, сувилагчийн албан тушаалтны тодорхойлолтыг арван гуравдугаар, ариутгагчийн албан тушаалтны тодорхойлолтыг арван дөрөвдүгээр, тогоочийн албан тушаалтны тодорхойлолтыг арван тавдугаар, угтах, хөтөч сувилагчийн албан тушаалтны тодорхойлолтыг арван зургаадугаар, туслах сувилагчийн албан тушаалтны тодорхойлолтыг арван долоодугаар, эм найруулагчийн албан тушаалтны тодорхойлолтыг арван наймдугаар, даатгалын эмчийн албан тушаалтны тодорхойлолтыг арван есдүгээр хавсралтаар баталсугай.

2. Байгууллагын бүтэц орон тоо, үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулсан албан тушаалын тодорхойлолтыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг ажилчдад үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган

ажилчдыг албан тушаалтны тодорхойлолтын дагуу ажилчдад танилцуулах ажлыг чанартай зохион байгуулахыг Хүний нөөцийн мэргэжилтэн (Г.Гантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Х.ГАНБАТ